



**ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/11

Батширээт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын "Ахмадын баярын өдөр"-ийг тохиолдуулан Засаг даргын Тамгын газрын харъяалалтай ахмадуудын гарын бэлэг гардуулах зардалд 952,660 (есөн зуун тавин хоёр мянга зургаан зуун жаран) төгрөг, ахмадуудаас тавьсан хүсэлтийн дагуу ахмадын байрыг зурагтаар хангах зардалд 929,900 (есөн зуун хорин есөн мянга есөн зуун) төгрөг, "Ахмадын өдөрлөг" зохион байгуулах зардалд 500,000 (таван зуун мянган) төгрөг, нийт 2,382,560 (хоёр сая гурван зуун наян хоёр мянга таван зуун жаран) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг "Ахмадын сан"-гаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Цолмон)-д зөвшөөрсүгэй.

3. Харъяалалтай ахмадуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.БҮДХАНД



232505021